


Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн 2378 дугаар албан бичгийн хавсралт



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2025 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН
(2025.01.01-09.25)**

2025 оны 09 дүгээр сарын 29

Улаанбаатар хот

НЭГ. Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн талаар:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавих, иргэнд хариу өгөх ажлыг зохион байгуулж дээд шатны байгууллагаас ирсэн үүрэг чиглэлийн дагуу тусгай төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 1085 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснээс хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 1022 буюу 95,03%, судлагдаж байгаа 63 буюу 4,7 хувь байна. Хуулийн хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 1, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 20 цаг 14 минут байна.

Нийт өргөдөл, гомдлыг өмнөх оны энэ үетэй харьцуулбал;



Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд ирүүлсэн өргөдлийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Өргөдөл, гомдлын төрлийг өмнөх оны энэ үетэй харьцуулбал;

Байгууллага	Он	Хүсэлт	Гомдол	Талархал	Санал	Мэдэгдэл	Нийт
Засаг даргын Тамгын газар	2024	539	771	5	33	5	1373
	2025	558	497	8	19	1	1085

Дээрх хүснэгтийг авч үзвэл 2025 оны гуравдугаар улирлын байдлаар гомдол 497 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Гомдлын тэргүүлэх 5 хандалт, гомдлыг бууруулах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ;

1. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ, павильон, ил задгай худалдаа, үйлчилгээний тухай 49 буюу 9.92%
2. Хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийн тухай 35 буюу 7.09%
3. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилтын тухай 32 буюу 6.48%
4. Хороодын үйл ажиллагааны тухай 25 буюу 5.06%

Дүүргийн хэмжээнд иргэдээс ирсэн гомдлын судлан үзэж, нэн шаардлагатай өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. Мөн иргэдийн гаргасан төсөв, санхүүжилт шаардлагатай гомдол, саналын шинжтэй өргөдлийг бүртгэж, 2026 оны төсөв, бодлого үйл ажиллагаанд тусгахаар ажиллаж байна.

Явган хүний зам, талбайн тохижилтыг сайжруулах ажил хийгдэж байна.

1. Дүүргийн хороодын байшин хороолол дундах автозамын нүхэн эвдрэлийн засвар 78.5% гүйцэтгэлтэй явагдаж байгаа бөгөөд одоогоор 19-р хороонд хийгдэж байна. Мөн Баянхошуу гудамжны хэсэгт шөнийн цагаар замын хөдөлгөөнийг хааж борооны ус зайлуулах системийн хоолойны ажлыг хийж гүйцэтгэсэн.



2. Төв замын хуучин хавтангаар гэр хорооллын гудамд тохижилтын ажлыг гүйцэтгэнэ. Тодруулбал дүүргийн 43 дугаар хорооны Алтайн 1 дүгээр хэсгийн

нарийн гудамжийг хуучин хавтан ашиглаж тохижуулах ажил 09 дүгээр сараас эхлэн хэрэгжээд байна.



Баянхошуу бүсийн иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор дүүргийн 24 дүгээр хороо Баянхошуу хайрхны баруун урд 4.5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлсэн. Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хийгдэж буй дээрх бүтээн байгуулалтын гүйцэтгэгчээр “Дүүрэн Трейд” ХХК ажиллаж байна. Тус бүтээн байгуулалтын ажил 11 дүгээр сард бүрэн дуусгаж Улсын комисст хүлээлгэж өгнө.

Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилтыг сайжруулах чиглэлээр

1. Дүүргийн спорт цогцолбор шинээр нээгдэж, 2600 м2 талбайд 20 гацуур болон өрөл, монос, долоогоно зэрэг нийт 320 мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.



2. Дүүргийн 1,2,34,20 дугаар хороог дамнасан 6.6 км үерийн далангийн ажил 93 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Одоогоор суурь ханын бетон цутгалтын ажил хийгдэж дуусан бөгөөд автомашины гарам гарцыг холбох ажлыг гүйцэтгэж байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж буй дээрх ажлын гүйцэтгэгчээр "Монгол менежмент" ХХК ажиллаж байна.

3. СХД 43-хороо Алтай 1 гудамжид ТҮЦ нүүлгэсэн байршилд таксины зогсоолыг томруулж, 140 метр явган хүний зам тавиад байна. Мөн “Оранж” дэлгүүрийн баруун талд явган хүний замын тохижилтын ажлыг гүйцэтгээд байна.



4. Сургууль, цэцэрлэгийн орчмын бүсэд авто зогсоол байгуулах газар чөлөөлөлтийн ажил үргэлжилж байна. Тодруулбал дүүргийн 4-р хорооны 226 цэцэрлэгийн орчимд газар чөлөөлөлт хийж 15 автомашины зогсоолыг байгуулахад бэлэн болжээ. Өнөөдрийн байдлаар 4, 10, 25, 30, 31, 41 дүгээр хороодын 11 иргэний 4786 м2 талбайтай газрыг нөхөн олговортойгоор чөлөөлөөд байна. Чөлөөлсөн дээрх байршлуудад авто зогсоолын зураг, төсөв боловсруулах тендер зарласан.

Хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийг сайжруулах чиглэлээр

Сонгинохайрхан дүүрэг хот нийтийн аж ахуйн тусгай зориулалтын 47 машин, техник төхөөрөмжөө шинэчилсэн ингэснээр ажлын бүтээмж, цаг хугацаа, үр дүн нэмэгдээд байна.



Хороодын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр

Хороодын албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан.



Хороодын үйл ажиллагаа болон цаг бүртгэлд хяналт тавих, албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан.



Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын хуулийн хугацаа хэтрүүлсэн 1 өргөдөл, гомдол байна. Үүнд:

Байгууллага	Мэргэжилтэн	Өргөдлийн дугаар	Төрөл	Огноо		Хэтэрсэн хугацаа /хоног/
Засаг даргын Тамгын газар	Д.Мөнгөндалай	G250502226	Гомдол	2025-05-02	2025-06-03	1.922
Шийдвэрлэлтийн байдал						
Дүүргийн 30 дугаар хороонд баригдаж буй сургуулийн барилга барьж буй байгууллагын захирал Гантулгын 99115304 дугаарын утсаар ярьж мэдээлэл авсан. Барилгын гадна тохижилтын ажлыг ирэх долоо хоногоос эхлүүлэхээр төлөвлөж байгаа тухайн иргэний асуудлыг эхний ээлжинд шийдвэрлэхээ мэдэгдсэн болно. Иргэний утсаар ярьж мэдээлэл өгсөн.						
Хугацаа хэтрүүлсэн тайлбар						
Өргөдлийг 2025 оны 05 угаар сарын 30-ны өдөр 28 хоног буюу 2 хоног дутуу байхад хаасан боловч шийдвэрлэлт шаардлага хангаагүй шалтгаанаар буцаагдаж хугацаа хэтэрсэн болно. Иргэний өргөдлийн дагуу гүйцэтгэгч "Монгол зам" ХХК-тай холбоо барьж асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд талаар иргэнд утсаар хариу хүргэж ажилласан. Тус албан хаагчаас дахин хугацаа хэтрүүлэхгүй ажиллах талаар тайлбарыг авч удирдлагад танилцуулсан.						

Засаг даргын Тамгын газрын өргөдөл, гомдол шийдвэрлэх явцад гарсан зөрчлийн дэлгэрэнгүйг авч үзвэл;

№	Хэлтэс, тасаг	Зөрчил гаргасан албан хаагч	Зөрчлийн төрөл			Нийт
			Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	Явцын тэмдэглэл хөтлөөгүй	
1	Удирдлага	Ц.Баттөр	1	5	-	6
2		Д.Баярсайхан	-	1	-	1
3	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	М.Мандаарий	-	-	1	1
4		Г.Нарангарав	-	2	-	2
5		Б.Номин-Эрдэнэ	3	1	-	4
6	Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	А.Батсайхан	-	3	-	3
7		Ө.Норовдэмид	-	-	1	1
8		Д.Мөнгөндалай	-	1	-	1
9	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	Р.Мөнхтуяа	-	1	3	4
10		Ц.Шинэхүү	-	-	1	1
11	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	Ч.Ариунтунгалаг	-	1	-	1
12		Ц.Бямбацолмон	-	1	3	4
13		Д.Цэдэнсүрэн	-	1	-	1
14	Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс	С.Туулмаа	-	2	-	2
15	Хөдөө аж ахуйн тасаг	С.Мижиддорж	-	1	-	1
16	Агаарын бохирдолтой тэмцэх тасаг	И.Оюунгэрэл	-	-	1	1
17	Аж ахуйн тасаг	Б.Анхзаяа	-	4	-	4
Нийт			4	24	10	38

Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр:

Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад хамгийн их зөрчил дутагдал гаргаж байгаа нэгж хороод байна. Хороодын өргөдөл, гомдол хариуцсан зохион байгуулагч, нийгмийн ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэхээр Өргөдөл, гомдол системийн хэрэглээ арга зүйн сургалтыг 09 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан.



Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн зөвлөлийн хуралдааны үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 7 хоног бүр өргөдөл, гомдлын мэдээ болон зөрчил гаргасан алба хаагчдын тайлбарыг хавсаргаж, хугацаанд нь хүргүүлж байна.

Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад удаа дараа зөрчил гаргасан байгууллагуудад Тамгын газрын 03/276, 03/475, 03/770, 03/1200, 03/1201, 03/1212, 03/1213, 03/2324, 03/2680, 03/2690-2694, 03/2698-2704, 03/2771 дугаартай албан бичгээр тус тус чиглэл хүргүүлсэн.

Засаг даргын Тамгын газрын хэмжээнд өргөдөл, гомдлын хуулийн хугацаа хэтрүүлсэн болон өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад удаа дараа зөрчил гаргасан албан тушаалтнуудад байгууллагын аппаратын хуралд хамт олны дунд хатуу анхааруулсан. Цаашид зөрчил давтан гаргасан албан хаагчдад шууд арга хэмжээ авч ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга анхааруулсан.

Дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурал, удирдах албан тушаалтны хурал, байгууллагын аппаратын хурлаар нийт 5 удаа өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг танилцуулсан.

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА А.БЯМБА

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Б.НОМИН-ЭРДЭНЭ

